



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/165

Улаанбаатар хот


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар бүлгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн 2019 оны батлагдсан төсвийн хүрээнд устгасан золбин нохой, муурын сэг зэмийг шатааж устгуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ /Б.Бямбадорж/-д үүрэг болгосугай.

2. Устгасан нохой, муурын сэг зэмийг шатаахад шаардагдах 122.971.240 /Нэг зуун хорин хоёр сая есөн зуун далан нэгэн мянга хоёр зуун дөчин/ / төгрөгийг Устгасан нохой, муурын сэг зэмийг шатаах, дарж булах зардлаас гүйцэтгэлээр санхүүжүүлж ажиллахыг Ахлах нягтлан бодогч Б.Цэрмаад зөвшөөрсүгэй.

3. Дээр дурдсан ажлын захиалагчийн хяналт тавьж ажилласан хөндлөнгийн хяналтын Төрийн бус байгууллагын санхүүжилтыг дээр дурдсан ажил тус бүрийн батлагдсан төсвийн 2%-аар тооцож олгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  С.ГАНТӨМӨР

